

“ХӨНГӨН БЕТОН” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2017.04.17

Улаанбаатар хот

Хурал 2017 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн 17:30 цагт “Хөнгөн бетон” ХК-ийн хурлын өрөөнд эхэлж 18:20 цагт дуусав. Хуралд нэр бүхий 4 хувьцаа эзэмшигч оролцов. Тооллогын комиссын дарга М.Буянхүү хувьцаа эзэмшигчдийн ирцийг танилцуулж саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийг танилцуулав.

Үүнд:

“Хөнгөн бетон” ХК-ийн зарласан бөгөөд гаргасан энгийн хувьцааны 179373 ширхэг хувьцаа ба ирсэн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй саналын эрхтэй хувьцаа 100006 ширхэг байгаа ба 56%-ийн ирцтэй байна. Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд зааснаар 50-иас дээш хувьтай гэж байгаа бөгөөд ирц 56%-тай байгааг хүчин төгөлдөр гэж үзэж хурлыг эхлүүлэв.

1. Б.Наранзул - 57399
2. Б.Наранцацралт - 26655
3. Б.Наранзул /“Минжит булган гол”ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/ - 14918
4. Ш.Энхтөр / Т.Баярхүүгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч / - 1034

Тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулав.

Хурлын дарга Б.Наранзул хурлыг нээж үг хэлэв.

“Хөнгөн бетон” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг нээснийг мэдэгдэе. Эхний ээлжинд хурлын дэгийг танилцуулъя. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр нь саналыг аваад шийдвэрлээд явах саналтай байна. Үүнтэй санал нэг байна уу?

Шийдвэрлэсэн нь: Өөр санал гаргаагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн саналаар хурлын дэгийг батлав.

Б.Наранзул: Тооллогын комиссын дүнг авъя.

Асуудал 1. Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, дүгнэлтийг хэлэлцэж батлах.

Б.Наранзул: Та бүхэнд 2016 оны үйл ажиллагааны тайлангаа цаасаар та бүгдийн өмнө гаргаж тавьсан байгаа. 2016 онд 507,5м³ блок үйлдвэрлэн борлуулж 119,2 сая төгрөгийн борлуулалтын орлоготой байлаа. Мөн энэ онд эдийн засгийн нөхцөл байдал хүнд үргэлжилсээр байгаатай холбоотой бүтээгдэхүүний үнэ буурч дундаж үнэ 110,030 төгрөг байсан барилгын салбарын уналттай холбоотойгоор захиалга багассантай холбоотой гэж үзэж байна.

Б.Наранцацралт: Энэ жил үйлдвэрлэл дээр ажиллах хүчний хувьд ямархуу байв?

Б.Наранзул: Улс орны болоод барилгын салбарын эдийн засгийн нөхцөл муудаж үйлдвэрлэлийн захиалга эрс буураад байгаа ба үйлдвэрлэлийг 2016 онд 1 ээлжээр 3 сар л ажиллуулсан.

Б.Наранзул: Та бүхэнд санхүүгийн тайланг хүргүүлсэн байгаа. 2016 оны борлуулалтын талаар би танилцуулчихлаа. Цахилгаан дулаан уур усны зардал жилээс жилд нэмэгдэж тогтмол зардал өсч байгаа нь үйлдвэрлэлийн хэмжээгээ ихэсгэхгүй л бол алдагдалтай ажилладах хүрээд байна. Мөн энэ онд нийт 316,6 сая төгрөгийн зээлийн хүүгийн зардал гарсан байна. Ингээд үйл ажиллагааны 350,9 сая төгрөгийн алдагдалтай ажиллалаа. Мөн валютын зээлтэй холбоотой нийт ханшийн зөрүүний алдагдал бодит бус 42,1 сая төгрөг байна.

Ш.Энхтөр /Т.Баярхүүгийн итгэмжлэгдсэн төлөөлөгч/: Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж хуучирсан болохоор сэлбэг хэрэгслэлийн олдоц нь хэр байдаг вэ? Ашиглалтын зардал хэр байна? Энэ талаар.

Б.Наранзул: Ашиглалтын зардал нь биднээс шууд хамааралгүй өөрчлөгддөг ба 90 орчим хувь нь үйлдвэрлэлийн өртөгт 10 хувь нь зардалд шингэдэг. Мөн засварын зардал нийт зардалд эзлэх хувь өндөр ба энэ нь сэлбэг хэрэгсэлийн олдоц муу, үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж хуучирч элэгдсэнтэй холбоотой.

Б.Наранзул: Компанийн 2016 оны үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг батлах уу?

Шийдвэрлэсэн нь: Өөр санал гараагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 %-ийн саналаар батлав.

Асуудал 2. Ногдол ашиг хуваарилахгүй талаар танилцуулах

Б.Наранзул: Ногдол ашгийн тал дээр ЕСББ-ны болон ХАС банкны хамтарсан зээлээр аливаа өр зээлийг төлж барагдуулах хүртэл ногдол ашгийг хуваарилж төлөхгүй гэсэн зээлийн гэрээний үүрэг хүлээсэн учир ногдол ашиг хуваарилах боломжгүй угаасаа компани алдагдалтай ажиллаж байгаа.

Б.Наранзул: За ногдол ашиг хуваарилахгүй байх талаар саналаа хураая. Гэрээний дагуу үүргээ биелүүлэхийг зөвшөөрч байна уу?

Шийдвэрлэсэн нь: Өөр санал гараагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 %-ийн саналаар батлав.

Б.Наранзул: 2017 оны 4 дүгээр сарын 17-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын № 01 тоот “Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг батлах, ногдол ашгийн тухай” тогтоолын төслийг хамтад нь танилцуулав.

Шийдвэрлэсэн нь: Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100% -ийн саналаар уг тогтоолын төслийг батлав.

Асуудал 3. ТУЗ-ийн хараат бус гишүүнийг нөхөн сонгох

Б.Наранзул: Өмнөх 8 гишүүдээ улируулан сонгоод, шинээр 1 гишүүн нөхөн сонгохоор оруулж ирж байгаа юм. Шинээр хараат бус гишүүний нөхөн сонгоход 2 хүний анкет ирүүлсэн байна. Та бүхэн анкеттэй нь танилцана уу. Анкетыг танилцуулав.

Б.Наранцацралт: Өмнөх гишүүдээс чөлөөлөх хүн байгаа юм уу?

Б.Наранзул: Өнөөдөр ТУЗ-ийн хараат бус гишүүн байсан Н.Мөнхцацрал гишүүнээс чөлөөлөгдөнө гэсэн үг.

Тошил овогтой Баярхүү ердийн гишүүнд

Баярхүү овогтой Наранзул ердийн гишүүнд

Баярхүү овогтой Наранцацралт ердийн гишүүнд

Болд овогтой Батбаяр ердийн гишүүнд

Бат-очир овогтой Эрдэнэбаяр ердийн гишүүнд

Баасанжав овогтой Алтанцэцэг ердийн гишүүнд

Алтангэрэл овогтой Мөнхзул хараат бус гишүүнд

Шаравсамбуу овогтой Энхтөр хараат бус гишүүнд улируулан сонгохоор санал оруулж байна.

ТУЗ-ийн хараат бус гишүүнд Н.Мөнхцацралын оронд нөхөн сонгохоор Янжив овогтой Хүрэлхүү, Норолхоо овогтой Энхжаргал нарыг шинээр нэр дэвшүүлэхээр санал оруулж байна.

Б.Наранзул: ТУЗ-ийн хараат бус гишүүнийг куммулятив аргаар сонгоно, нэр дэвшсэн хүмүүст өгөх саналын тоогоо өгөөд саналаа хураая. /Саналын хуудсаа тараав./

Тооллогын комисс саналын хуудсуудыг авч нэгдсэн дүнгээ гаргаад нэр дэвшсэн хүмүүст өгсөн саналын тоог гаргаад танилцуулаарай.

Тооллогын комиссын дарга М.Буянхүү: ТУЗ-ийн хараат бус гишүүн сонгох саналын дүнг танилцуулав.

Янжив овогтой Хүрэлхүү 100006 санал
Норолхоо овогтой Энхжаргал 0 санал
тус тус өгч ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Я.Хүрэлхүү сонгогдлоо.

Б.Наранзул: 2017 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын №02 тоот тогтоолын төслийг танилцуулав.

Шийдвэрлэсэн нь : Өөр санал гараагүй тул хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100% - ийн саналаар ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгох тогтоолын төслийг батлав.

Б.Наранзул: За ингээд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хаасныг мэдэгдье.

ХУРЛЫН ДАРГА

Б.НАРАНЗУЛ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

Б.УНДРАХ

